



МОНГОЛ УЛСЫН
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2014 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 128

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Шүүхийн захиргааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ТОГТООХ нь:

1."Шүүхийн хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг шүүхийн төсөв, гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан жил бүр төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга /Т.Мэндсайхан/-д үүрэг болгосугай.


ДАРГА



Н.ЛҮНДЭНДОРЖ

001500

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014
оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн
128 дугаар тогтоолын хавсралт



“ШҮҮХИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЫГ ХӨГЖҮҮЛЭХ”

ХӨТӨЛБӨР

НЭГ.ЗОРИЛГО

Шүүхийн хүний нөөцийг бэлтгэх, шүүгч, ажилтныг чадавхжуулах, хөгжүүлэхэд энэ хөтөлбөрийн зорилго оршино.

ХОЁР.ЗОРИЛТ

1. ШҮҮХИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БЭЛТГЭХ

Зорилт 1. Хууль зүйн их, дээд сургуулийн сургалтад шүүхийн эрх зүйн сургалт, судалгааг нэмэгдүүлэх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх.

Зорилт 2. Хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудыг шүүхэд дадлагажуулах ажлыг дэмжих.

Зорилт 3. Эрх зүйч болон хуульчдын дунд шүүхийн эрх зүйн судалгааг хөгжүүлэх, дэмжих.

Зорилт 4. Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх.

Зорилт 5. Шүүхийн захиргааны мэргэшсэн ажилтан бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх.

2. ШҮҮГЧ, ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ АЖИЛТНЫ ЧАДАВХЫГ ХӨГЖҮҮЛЭХ

Зорилт 6. Хуульчдаас шүүгчийг шилж олох ажиллагааг үр нөлөө, бүтээмжтэй болгох.

Зорилт 7. Шүүгчийн үргэлжилсэн сургалтын агуулгыг үе шаттайгаар шинэтгэж, хэрэгжүүлэх.

Зорилт 8. Шүүхийн захиргааны ажилтны үргэлжилсэн сургалтын агуулгыг үе шаттайгаар шинэтгэж, хэрэгжүүлэх.

Зорилт 9. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны тасралтгүй боловсролыг дэмжиж, хэрэгжүүлэх.

ГУРАВ.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зорилт 1. Хууль зүйн их, дээд сургуулийн сургалтад шүүхийн эрх зүйн сургалт, судалгааг нэмэгдүүлэх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх.

-Хууль зүйн их, дээд сургуулийн шүүхийн эрх зүйн хичээлийн сэдвийн хүрээ, агуулгыг тодорхойлоход мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх.

-Шүүх эрх зүйн хичээлийн хөтөлбөрийг нэгдсэн стандартад оруулах, нэр төрлийг нэмэгдүүлэх асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлүүлэх.

-Хууль зүйн их, дээд сургуулийн оюутан, эрх зүйч, хуульчдын дунд Шүүхийн мэтгэлцээн (Mock trial)-ийг жил бүр зохион байгуулж, мэтгэлцэх ур чадварыг хөгжүүлэх.

Зорилт 2. Хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудыг шүүхэд дадлагажуулах ажлыг дэмжих

-Шүүхэд оюутныг дадлагажуулах ажлын үр нөлөөг дээшлүүлэх, сургууль, шүүхийн захиргааны хамтын ажиллагааг өргөжүүлэх.

-Хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудын дунд шүүхийн эрх зүйн чиглэлээр эрдэм шинжилгээний бүтээлийн уралдааныг жил бүр тогтмол зохион байгуулах.

Зорилт 3. Эрх зүйч болон хуульчдын дунд шүүхийн эрх зүй, практикийг судлах ажлыг өргөжүүлэх, дэмжих.

-Эрх зүйч, хуульчдын шүүхийн эрх зүйг хөгжүүлэх шинэ санаа, инновацийг практикт нэвтрүүлэх, захиалгат судалгаа гүйцэтгүүлэх.

-Шүүхийн шинэтгэлд үнэтэй хувь нэмэр оруулсан, шүүхийн шийдвэрт шилдэг анализ хийсэн судлаачийг шалгаруулж, урамшуулах.


-Шүүхийн эрх зүйг хөгжүүлэх арга хэмжээ /нээлттэй лекц, хэлэлцүүлэг, илтгэл, эрдэм шинжилгээний бүтээлийн уралдаан/-г жил бүр тогтмол зохион байгуулах.

Зорилт 4. Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх.

-Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоог бий болгох шаардлага, үндэслэлийг судалж, холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

-Шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцох хуульчдын сургалт, дадлагын тусгай хөтөлбөрт хамрагдах эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэх, бодлогын хувилбар гаргаж хэрэгжүүлэх.

Зорилт 5. Шүүхийн захиргааны мэргэшсэн ажилтан бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх



-Шүүхийн захиргааны ажилтныг бэлтгэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.

-Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнг өргөжүүлж, шүүхийн захиргааны сургууль, улмаар шүүхийн академи байгуулах үндэс суурийг тавих, бэлтгэлийг хангах.

Зорилт 6. Хуульчдаас шүүгчийг шилж олох ажиллагааг үр нөлөө, бүтээмжтэй болгох.

-Шүүхийн мэргэшлийн хороонд салбар эрх зүйгээр мэргэшсэн шүүгч, эрдэмтэн, хуулийн сургуулийн профессор байх эрх зүйн орчныг бүрдүүлэх.

-Шүүгчийн сонгон шалгаруулалтын шалгалтын төрөл, хэлбэрийг боловсронгуй болгох судалгааг хийж, бодлогын шийдэл олох, эрх зүйн орчныг бүрдүүлэх.

-Шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагааг иж бүрэн програмжуулах, нууцлалыг баталгаажуулах, ил тод, нээлттэй болгох.

Зорилт 7. Шүүгчийн үргэлжилсэн сургалтын агуулгыг үе шаттайгаар шинэтгэж, хэрэгжүүлэх

-Сургалтын хөтөлбөрийг үе шаттайгаар тогтмол шинэчлэх, олон хувилбарт шилжүүлж, сонгон суралцах боломжийг бүрдүүлэх.

-Сургагч багшийг бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэх тогтолцоог бий болгох, шүүгч шүүгчийн сургалтад багшлах, судалгаа хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Зорилт 8. Шүүхийн захиргааны ажилтны үргэлжилсэн сургалтын агуулгыг үе шаттайгаар шинэтгэж, хэрэгжүүлэх

-Сургалтын хөтөлбөрийг үе шаттайгаар тогтмол шинэчлэх, олон хувилбарт шилжүүлж, сонгон суралцах боломжийг бүрдүүлэх.

-Сургагч багшийг бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэх тогтолцоог бий болгох.

Зорилт 9. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны тасралтгүй боловсролыг дэмжиж хэрэгжүүлэх

-Шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг магистр, докторт суралцахад дэмжлэг үзүүлэх.

-Шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг өндөр хөгжилтэй оронд магистр, докторын сургалтын хөтөлбөрт хамруулах, дэмжлэг үзүүлэх.

ДӨРӨВ.ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, САНХҮҮЖИЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН


Хөтөлбөрийг 2015-2020 оныг дуустал хэрэгжүүлнэ. Улсын төсөв болон Монгол Улсын олон улсын гэрээгээр нийлүүлэх хөрөнгө, зээл, тусламж, төсөл, хөтөлбөрөөр санхүүжүүлнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

- Хууль зүйн их, дээд сургуулийн шүүхийн эрх зүйн сургалт, судалгааны тоо, чанар.
- Шүүхийн эрх зүйн судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлийг практикт нэвтрүүлсэн, дэмжсэн үйл ажиллагааны тоо.
- Мэргэшсэн хуульч болон шүүхийн захиргааны мэргэшсэн ажилтны тоо.
- Шүүгчийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны хөндлөнгийн байгууллагын үнэлгээ.
- Үргэлжилсэн сургалт болон тасралтгүй боловсролыг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан шүүгч, шүүхийн захиргааны ажилтны тоо.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх шүүгч, шүүхийн захиргааны ажилтны үнэлгээ
- Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны мэдлэг, ур чадварын талаарх олон нийтийн үнэлгээ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

- Шүүхийн хүний нөөцийг бэлтгэх үр нөлөө бүхий тогтолцоо бий болсон байна.



-Нийт шүүхийн захиргааны хүний нөөцийн 50-иас доошгүй хувь нь шүүхийн захиргааны мэргэшсэн ажилтнаар бүрдэнэ.

-Шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг сургаж, хөгжүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар шинэтгэж, хэрэгжүүлсэн байна.

-Магистр, докторын зэрэгтэй шүүгч, шүүхийн захиргааны ажилтны тоо 2 дахин нэмэгдэнэ.

-Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны мэдлэг, ур чадвар дээшилж, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлнэ.

-оОо-

